INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES

President Sh.Ozawa (Japan)

Vice-Presidents Ch.Bawden (UK)
Chingeltei (PRC)
W.Heissig (FRG)
Sh.Natsagdorj (Mongolia)
V.M.Solntsev (Russia)
R.Sharma (India)
I.Rachewiltz (Australia)

Secretary-General Sh.Bira (Mongolia)

EDITORIAL BOARD OF THE "MONGOLICA" INTERNATIONAL ANNUAL:

Sh.Bira (Editor in Chief) Mongolia,
A.Derevyanko (Associate Editor) Germany,
K.Sagaster (Associate Editor) Germany,
Chingeltei (China),
B.Dashtseren (Mongolia)
R.Hamoyon (France),
M.Murakami (Japan)
R.Sharma (India)
V.Veit (Germany)
Kh.Purevtogtokh (Executive Secretary and Volume editor)
M.Altantsetseg (Technical Editor)
Ch.Narantuya (Computer typist)
Editorial address: Sukhbaatar Square-3
Ulaanbaatar-11
Mongolia
Office of the IAMS Secretariat, P.O.20A
E-mail: iams@magicnet.mn
Fax: (976-11) 321328

The views expressed, data and events mentioned in this journal are not necesarily endorsed and shared by the Editorial Board or by the IAMS

ISSN 1024-3143

ISSN 1024-3143

MONGOLICA

AN INTERNATIONAL ANNUAL OF MONGOL STUDIES

VOL. 11 (32), 2001

A Special Issue Containing the Papers of the
Seventh International Congress of Mongolists
Convened under the Patronage of N.Bagabandi,
President of Mongolia
(12-16 August, 1997, Ulaanbaatar)

VOLUME III

Ulaanbaatar

The Secretariat of the International
Association for Mongol Studies

Ивээн тэтгэсэн байгууллагууд:

- **Монгол Улсын Засгийн Газар**
- **НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага**
- **Япон сан**
- **Сасакава сан**

Sponsors:

- **Government of Mongolia**
- **UNESCO**
- **Japan Foundation**
- **Sasakawa fund**

Олон Улсын Монгол Судлалын Холбоо
International Association for Mongol Studies

SEVENTH INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Volume III

2-р салбар /Section II/

Хэл бичиг
Mongolian Language and Letters

Салбар хуралдааны дарга проф. Д.Төмөртогоо
Chairman of the Section Prof. D.Tomortogoo

Нарийн бичгийн дарга. Ж.Бат-Ирээдүй
Secretary of the section J.Bat-Ireedui

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН"-Д ГАРАХ *"külüg"* ХЭМЭЭХ ҮГИЙН УТГА, ГАРАЛ ХУВЬСАЛ

Ш.Чоймаа (Монгол)

"Külüg" хэмээх энэ үг нь VII, VIII зууны үеийн Монгол дахь рун бичгийн дурсгалд ямар утгатай хэрэглэгдэж байсныг эхлэн өгүүлье.

1891 онд Ядринцев олж илрүүлсэн Онгийн голын дурсгал (Das Denkmal am Ongun) нь В.Радловын тодолсноор 692 онд (луу жил) бичигджээ. Уг бичээсэнд "...lÿ jылка bilrä kÿlÿг äp äггÿ kan тачам ölтi" (1-252) гэж буй. Түүнийг С.Е.Малов "... в дракона год, мудрый славный муж, благородный хан Тачам умер" (2-11) гэж орчуулсан бол В.Радлов "... im Drachen Jahre, der weise, der berümte Held, der gute Chan Tatscham ist gestorben" (1-252) гэж орчуулжээ.

Эрдэмтэн М.Шинэхүү Ховдын Дарви сумд буй эртний түрэг бичээсийг 1969-70 онд нягтлан уншаад " külük ata apa bit" (3-140) гэсэн бичээсийг "нэрт (алдарт) эцэг эхий минь төрхтөн" (3-142) хэмээн орчуулжээ.

Эртний түрэг бичээст гарах ***"külüg"*** хэмээх үгийг дээрх эрдэмтэд "славный", "der berühmte", "нэрт (алдарт)" гэж орчуулсан байх бөгөөд В.Радлов "Би ***"külüg"*** гэдэг үгийг ***"kül+g"*** буюу эсвэл ***"kü+lüg"*** гэсэн бүтэцтэй байсан гэж бодно. Тэгвэл угаасаа "алдарт" (der Berühmte) гэсэн утгатай үг болно. Kudatku - Bilik болон хойд зүгийн (түрэгийн) аялгуунд ***"külüg"*** гэдэг үг нь зөвхөн "баатар" гэсэн утгатай буй (1-220) гэж тэмдэглэжээ.

"Külüg" гэдэг үг нь ***"kü+lüg"*** гэсэн бүтэцтэй бөгөөд уг хоёр бүтээврийн (морфемын) тухай тодруулан авч үзье. Эртний түрэг хэлэнд ***"kü"*** гэдэг нь алдар, цуу гэсэн утгатай бөгөөд ***"kü cav"*** (молва, весть, слова) гэж хоршин хэрэглэгддэг байна (4-322).

Уйгуржин монгол бичгийн дурсгалд "цуу" гэдэг үгийг "cav–cau" гэж бичдэг бөгөөд тухайлбал 14-дүгээр зууны үед Чойжи-Одсэр орчуулсан гэж үздэг *"Банзрагч"* судрын төгсгөлийн шүлэгт "... aldar anu cinggis qaγan kemen jambudwib-tur cav (cau) boljuqui" (5-128) гэж буй. Мөн эртний түрэг бичээст "külüg bilgä" (знаменитый мудрец, алдартай мэргэн), "külüg cavliγ" (славный, знаменитый, алдар цуутай) (4-326) гэсэн хоршоо үг байдаг.

"Külüg" гэсэн үгийн 2 дахь бүтээвэр "-lüg" нь эртний түрэг, монгол хэлэнд их идэвхтэй хэрэглэгдэж байсан бөгөөд -luq, -lük, -liq, -lik, -luγ, -lüg, -liγ, -lig гэсэн олон хувилбартай тохиолддог. Түүнчлэн, орчин цагийн түрэг төрлийн хэлнүүдэд ч идэвхтэй хэвээр байгаа хийгээд уйгур хэлэнд нэг үгэнд 2 дахин залгаж, өөр өөр утга үүргийг илэрхийлж болдог ажээ. Жишээ нь: уйгур хэлний "чирай" (черты лица, красота лица) (царай) гэдэг нэр үгэнд -лиқ дагаврыг залгавал "чирайлиқ" [чирай+лиқ] (красивый) гоё, ганган, сайхан гэсэн утга бүхий үг бүтдэг бөгөөд монгол хэлний "царайлаг" гэсэнтэй дүйх тэмдэг нэр үүсдэг байна. Харин түүнд дахин -лик дагавар залгавал "чирайлиқлиқ" (красота) "гуа үзэсгэлэн" гэсэн хийсвэр утгатай жинхэнэ нэр үүсэх ажээ (6-228).

Монгол бичгийн хэлэнд -liγ, -lig гэсэн хувилбартай бөгөөд дундад үеийн монгол хэлэнд илүү идэвхтэй хэрэглэгдэж байсан бололтой. "Мукаддимат ал-адаб" толинд qudalciliq (худалч гэдгээс) (7-308), mūliq (муу гэдгээс) (7-243), sainliq (сайн гэдгээс) (7-317), jala'ūliq (залуу гэдгээс) (7-200), hayasqulik (баясгалан гэдгээс) (7-115), qaranquluq (харанхуй гэдгээс) (7-292), andalik (анд гэдгээс) (7-64) гэх мэт хийсвэр нэр олонтаа тохиолдож байна.

Энэхүү олон хувилбар бүхий -luq, (-lük) дагавар нь эртний болоод орчин цагийн түрэг, монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгддэг бөгөөд жинхэнэ нэр, тэмдгийн нэрд залгаж, уг нэрийн утгат зүйлээр элбэг баян буюу түүнийг агуулсан, эзэмшсэн гэсэн утгатай голдуу хийсвэр нэр бүтээдэг байна. Жишээ нь:

Монгол хэлэнд:	**Эртний түрэг хэлэнд:**
amta-amtaliγ	tatiγ (амт) - tatiγliγ (амтлаг) - (4-541)
uqaγan-uqaγaliγ	ög (ухаан) - öglüg (ухаалаг, ухаантай) (4-378, 380)
bayan-bayaliγ	bay (баян) - bayliq, bayluq (баялаг) (4-79)

bayatur-bayaturliγ	batur (баатар) - baturluq (баатарлаг) (4-89)
čečeg-čečeglig	čečäk (цэцэг) - čečäklik (цэцэглэг, цэцэрлэг) (4-557)
temür-temürlig	temür (төмөр) - temürlüq (төмөр бүхий) (4-551)
usu-usuliγ	suv (ус) - suvluγ (услаг, усархаг) (4-515)

гэх мэт.

Дээр өгүүлснээс нэгтгэн үзэхэд, *"külüg"* хэмээх үгийн *"kü"* гэдэг язгуур нь "алдар, цуу" (4-322) (8-306) гэсэн утгатай бөгөөд түүнд *-lüg* дагавар залгаснаар "алдар, цуу бүхий", "алдар цуутай" гэсэн хийсвэр нэр бүтсэн бөгөөд эртний түрэг, монгол хэлэнд энэ л утгаараа хэрэглэгдэж байжээ.

Уг үгийн утга улиран хувьсч "ухаантай, мэргэн, цэцэн, гарамгай, шилдэг гэх мэт ойролцоо олон утгыг илтгэх болсны жишээ гэвэл хаккас хэлэнд "күлүк" (умный, удалой) гэдэг нь ухаантай эрэмгий, шор хэлэнд "күлүк" (мудрый) гэдэг нь цэцэн мэргэн, алтай хэлэнд "күлүк" (именитый) гэдэг нь нэр төртэй, нэр хүндтэй, тувагийн ярианы хэлэнд "хүлүк" (удалой) гэдэг нь эрэмгий зоригтой гэсэн утгаар хэрэглэгдэж байна (9-227).

Монгол хэлэнд "külüg" хэмээх үг нь "külüg mori, külüg bayatur гэх мэт үгэнд "алдар цуутай" гэсэн тодотгол үгийн утгаар хэрэглэгдэж байгаад, орчин цагийн монгол хэлэнд külüg гэдэг тэмдэг нэр нь нэршиж, жинхэнэ нэрийн утгаар хэрэглэгдэх болжээ. Үүнийг "Монголын нууц товчоо"-ны баримт нотолж байгаа юм.

МНТ-нд "külüg" гэдэг үг 19 удаа гарч байгаа бөгөөд 11 удаад нь Чингис хааны дайчин баатар, шударга сайд, алдар гавьяатан Боорчи, Мухали, Борохул, Чулуун дөрвийг нэрлэн заахад хэрэглэжээ. Тэрхүү 11 удаагийн тохиолдолд, "külüg" хэмээх үгийг хятад хадмалд "jié" (节) хэмээх "шалгарсан, товойсон, гарамгай, шилдэг" гэсэн утга бүхий үгээр орчуулсан байна. Тус орчуулга нь "külüg" хэмээх үгийн "алдар гавьяа бүхий" гэсэн алтай хэлний эртний утгатай нийцэж байгаа бөгөөд зарим судлаачид (10-162), (11-470) хүлэг морьтой адилтгасан үг мэтээр буюу хүлэг морь гэсэн үгийн шилжсэн утга гэж тайлбарласан үзэгддэг нь ташаа зүйл болой.

МНТ-ны 45, 46 дугаар зүйлд "qaci külüg" гэдэг хүний нэрд 2 удаа тохиолдож байна.

МНТ-ны 3, 254 дүгээр зүйлд нэр үгийн тодотголоор хэрэглэсэн байна. Үүнд:

§ 3. ... dayir boro qoyar "külü'üd aqtastu büle'e... (12-13)

Энэ нь "дайр бор хоёр хүлэг (алдартай) агт (морь)-тай бүлгээ гэсэн утгатай бөгөөд "külüg" гэдэг үгийн хятад хадмал нь "jùn" (骏) үг буй.

§ 254...töreksen dörben külü'üt kö'üd-ü'en ken-i inü ke'emü" (12-149) гэж тохиолдоно.

Дээрх хэсгийг Ц.Дамдинсүрэн, Мансан нар:

"Төрсөн дөрвөн хүүгээс чинь

Төр барих нь хэн бэ" гэж "külüg" хэмээх үгийг хасаж буулгасан байх ба бусад судлаачид эхээр нь хөрвүүлжээ. Хятад хадмал орчуулгад нь "jùn jié" (俊 节) гэсэн үг буй. Аггас, хөвгүүд гэсэн хоёр үгийн тодотгол нэр болсон "külüg" гэдэг үгийн хадмал хятад ханз "jun" гэдэг нь зөвхөн морийг заасан, хүнийг заасан түлхүүр ханзаараа л ялгарч байгаа бөгөөд "шилдэг, чадамгай, алдарт" гэсэн утгатай байх ажээ.

МНТ-нд гарч буй дээрх "külü'üt kö'üd" гэдгийг алдар цуутай хөвгүүд гэж буулгавал зохих юм. МНТ-ны 201 дүгээр зүйлд Жамухын үгэнд ...anda secen eketü törülki külük törejü...(12-112) гэж буй. Түүнийг Ц.Дамдинсүрэн гуай шүлэглэн буулгасан тул "...эрэлхэг баатар..." гэдэг үг л "törülki külük" гэдэгтэй дүйж байна. Академич Д.Цэрэнсодном "anda secen eke-tei törülki joriγ bayaturliγ (külüg) törüjei" (13-183) хэмээж, Мансан "anda ta secen eke-dü jayayaju cigeci jirum törübe" (10-246) гэж хөрвүүлжээ. Хятад хадмал орчуулгад нь "jùn jié" (俊 节) гэсэн бөгөөд өмнө өгүүлсэн "kö'üd" гэдгийн тодотгол "külük" гэсэн үгийн хадмал орчуулгатай адил байгаа болно. МНТ-ны энэ хэсгийг "алдар цуутай төрж" гэж хөрвүүлэх нь зөв буй заа.

МНТ-ны 205 дугаар зүйлд Чингис хаан өөрийн насан бага цагт нь чин үнэнч сэтгэлээр нөхөрлөсөн хүлэг баатар, шударга сайд Боорчийн ач гавьяаг дурдан өгүүлэхдээ:

...sedkil-ün külüg-iyer nökücebe-je ci...

külüg-ün cinu belge aju'u-je. te'ün-ece busu ali külüg-i cinu ügülejü da'usqu (12-117) гэж буй.

МНТ-ны энэ хэсгийг Ц.Дамдинсүрэн гуай "Чи үнэн сайхан сэтгэлээр нөхөрлөв... Хүлэг баатрын шинж энэ мөн. Түүнээс

бусад чиний зүтгэлийн алийг хэлж барах вэ" (14-178) гэж буулгажээ.

Мансан "tere qaraqan külüg bayatur-un jirum-un sedkil bui j-a... tere qaraqan külüg bayatur-un belge sinji bui j-a. egün-eče busu cinu bayatur üile-yi ali-yi ni kelejü baraqu bui" (10-252) хэмээн хөрвүүлсэн бол Д.Цэрэнсодном "sedkil-ün joriγ-iyar nökürlebe j-e ci. joriγ (sedkil)-un cini belge ajuγu j-e. tegün-eče busud ali joriγ (sedkil)-i cini ögülejü dayusun-a"(13-190) гэж буулгажээ. Бусад судлаачид эхийг хэвээр нь хөрвүүлжээ.

МНТ-ны 205 дугаар зүйлд гарч буй дээрх "külüg" гэдэг үгийн хятад хадмал орчуулга нь "háo jié" (豪 傑) бөгөөд "баатар, баатарлаг" хэмээх утгатай ажээ.

БНХАУ-ын судлаач Мөнх *"Сэтгэлийн хүлэг"-ийн тухай гүн ухааны задлалт"* гэсэн тусгай өгүүлэл бичиж, МНТ-ны 205-дугаар зүйлд гарч буй "külüg" гэдэг үгийг ямар утгаар тохиолдож байгааг тун нарийвчлан шинжилж, сонирхолтой дүгнэлт хийжээ. Гэвч мөн л зарим судлаачдын адил хүлэг морьтой холбон үзэж "külüg-iyer kümün-ü kergem čola-yi todudqaqu jangsil-du olan tal-a-yin siltayan bayiqu bolbaču külüg-ün sinji belge cidal tengkege-yi ündüsülegsen ni nigen ciqula siltayan bolju meden-e" (15-12) гэж бичжээ.

"Külüg" нь ажнай морийн нэр болж, külüg ayta, külüg mori гэсэн үгийн ayta, mori хэмээх үг хураагдан хэмнэгдэж, külüg гэсэн тодотголоор орсон тэмдэг нэр нэршсэн нь хожуу үеийн хувьсал болно.

Харин " külüg" хэмээх үгийн -lüg дагаврын олон утга илтгэх шинжээс хамаарч, уг үг баатарлаг, мэргэн, цэцэн, гавьяа, гарамгай, шилдэг гэх мэт олон ойролцоо утгатай үг буй болсон бөгөөд тухайн нэрийн утга дагуу хийсвэр утгат жинхэнэ нэрийг ч илэрхийлж байжээ.

МНТ-ны 205 дугаар зүйлийн дээрх хэсэг нь миний бодлоор бол "Сэтгэлийн баатарлагаар нөхцөв л чи... Алдар цуугий чинь бэлгэ ажээ. Түүнээс бус аль алдар гавьяаг чинь өгүүлж дуусах..." гэсэн утгатай ажээ.

Дундад үеийн монгол хэлэнд külüg гэдэг үг ямар утга илэрхийлж байсан хийгээд дээрх саналыг нотлох нэгэн баримт бол Чойжи-Одсэр орчуулсан гэж үздэг "Банзрагч" /Pancarakca/-ийн төгсгөлийн шүлэгт буй "...ded köbegün-ü γutaγar üy-e-dür inü

tengsel ügei qayisan neretü törüjü bürün köbegün čaγ-ačaγan ber uridus-tur kösigürkegsen-i külüg-iyer-iyen ölüdkejü gür ulus-un ejen boluγaγdaju bürin-e külüg qaγan kemen aldarsiγsan..." гэсэн хэсэг юм.

Энд гарч буй "урьдаст хөшүүрхсэнийг хүлгээрээ өлтгөж" гэдэг нь өмнөх хаадын үед өөр санаа өвөрлөгчдийг "алдар цуу"-гаараа номхотгож гэж өгүүлсэн хэрэг бөгөөд тэрхүү "külüg" хэмээх үгийн утга нь өмнө өгүүлсэн санааг баталж байгаа болов уу.

МНТ-нд тохиолдох "külüg" хэмээх үгийн утга хийгээд уг үг нь "алдар цуу" бүхий гэсэн утгатай байгаад агт, морь, баатар гэсэн үгний тодотголоор тогтвортой хэрэглэгдэж, улмаар нэршиж орчин цагийн монгол хэлэнд сайн морь, ажнайг нэрлэх болжээ гэсэн өөрийн дүгнэлтээ өгүүлэв.

Энэ ялдамд дурдахад, "külüg" нь орчин цагийн монгол хэлэнд "kölge" гэсэн үгтэй утга самуурах тал бас гарч буй. Энэхүү "köl-" гэдэг нь үйл үг бөгөөд алтайн хэлэнд морь, үхэр зэргийг тэргэнд хөллөхийг тийн хэлдэг билээ.

Дээрх köl- гэсэн үйл үгийн язгуурт үйлээс нэр үг бүтээх -ge дагавар залгаж, унаа, унаш, тээврийн хэрэгсэл гэсэн утгатай нэр үг бүтсэн буй. Буддын шашны судар шастирыг их хөлгөн судар хэмээдэг нь орчлонгийн зовлонгоос гэтэлгэн нирваанд хүргэх унаа хөлгө гэсэн утгаар нэрлэсэн ажээ.

Санскрит хэлний yāna, түүнтэй дүйх төвд хэлний thig-pa (ཐེག་པ།) гэдэг үгийг монгол хэлэнд хөлгөн хэмээн орчуулдаг бөгөөд санскрит хэлний yāna хэмээх үгийн нэг салаа нь унаа хөлгө гэсэн утгатай билээ.

Эцэст нэгэн зүйлийг тэмдэглэн хэлэхэд, кирилл үсэгт суурилсан орчин цагийн монгол хэлний зөв бичих дүрэмд "külüg", "kölge", külig" гэсэн гарал, утга нь эрс өөр гурван үгийн бичлэг будлиантай байдаг бөгөөд журамлах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН НОМ

1. **W.Padloff**, *"Die alttürkischen inschriften der Mongolei"*, Band I (Neudruck der Ausgabe St.Petersburg 1894) Otto zeller verlag osnabrück 1987.
2. **С.Е.Малов**, *"Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии"*, М-Л.1959.
3. **М.Шинэхүү**, *"Даривын эртний түрэг бичээс"*, "Монголын эртний түүхийн зарим асуудал", УБ, 1972, 135-147.
4. *Древнетюркский словарь*, Ленинград, 1969.
5. *"Qutuγtu pancaraksa kemekü tabun sakiyan neretü yeke kölgen sudur"*, Herausgegeben von Pentti Aalto, Otto Harrassowitz-Wiesbaden, 1961.
6. *Строй Уйгурского языка*, Алма-Ата, 1989.
7. **Н.Н.Поппе**, *"Монгольский словарь Мукаддимат ал-адаб"*, М-Л, 1938.
8. *Martti Räsänen, "Versuch eines etymologischen wörterbuchs der Türksprachen"*, Helsinki, 1969.
9. **И.А.Батмонов, З.Б.Арагачи, Г.Ф.Бабушкин**, *"Современная и древняя Енисенка"*, Фрунзе 1962.
10. **Mansang** *"Sin-e-ber orciγulju tayilburilaγsan mongγol-un niγuča tobciyan"*, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1985.
11. **Eldengtei** *"Mongγol-un niγuča tobciyan-seyiregülül tayilburi"*, öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a, 1986.
12. **Igor de Rachewiltz**, *Index to the secret History of the Mongols*, Bloomington 1972.
13. **D.Ceringsodnom**, *"Mongγol-un niγuča tobciyan"-u orciγulγ-a tayilburi"*, ündüsün-ü keblel-ün qoriy-a, 1993.
14. *Монголын Нууц Товчоо*, Ц.Дамдинсүрэн орчуулав, УБ, 1957.
15. **Möngke**, *"Sedkil-ün külüg"-ün tuqai gün uqaγan-u ǰadalulta "γabiy-a ǰidkül-ün durasqal"*, (Профессор М.Хайссигийн 80 насны ойд), "öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a", 1993, 10-28.

ЭРТНИЙ МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Ц.Шагдарсүрэн (Монгол)

Монгол хэлний хөгжлийн түүхийг нэхэн үзвэл Өвөг болоод Эртний монгол хэлний судалгаа харьцангуй бага гэж хэлж болох бөгөөд профессор П.Пеллио (P.Pelliot), К.Ширатори (k.Shiratori), Л.Лигети (L.Ligeti), Н.Поппе (N.Poppe), Лүй Базен (Lui.Bazin), П.А.Бүүдберг (Peter A.Boodberg),О.Прицак (O.Pritsak), Г.Дөрфер (G.Deorfer) зэрэг гол төлөв гадаадын ахмад үеийн монголч эрдэмтэд тэрхүү судалгааг хийсэн нь тухайн судлагдахууны онцлогтой даруй холбоотой буй заа.

Дээр нэр дурдсан эрдэмтдийн судалгаанд дулдуйдаж монгол хэлний харьцангуй түрүү үеийн баримт хэрэглэгдэхүүнийг боломжийн хирээр нэгтгэн үзэх явцад хийсэн ажиглалт болоод холбогдох шинэвтэр баримт сэлтэд тулгуурлаж нэлээд томоохон тойм өгүүлэл бичсэн бөгөөд энэ удаа тэрхүү өгүүлэлд дэвшүүлсэн зарим нэгэн санааг энд товч танилцуулах нь зүйтэй гэж бодож байна.

Нэгэн зүйл: 1970-аад оны үед академич Л.Лигети авгай "Табгач хэл-хятан хэлний нэгэн аялгуу болох нь" гэдэг өгүүлэлдээ, Kelmmürčin (k'i-wan-tchen, эртний хятад дуудлага: k'ɪĕit-miwan-t'śiĕn, табгачаар: kelmürčin) гэдэг үгийн тайлбарт "..Тангийн үеэс өмнө, харь үгийн дэвсгэр -r авиаг үе хаасан -n-ээр тэмдэглэж заншсан байлаа. Харин харь хэлний kel (буюу kil) гэдэг үеийг k'iĕt хэмээн тэмдэглэж заншаагүй бөлгөө. VIII зуунаас өмнө үе хаасан -t-б-г (L) болох явдал байгаагүй..." гэж Х.Масперо (H.Maspero)-гийн судалгаанд үндэслэж дурдсан нь